



МОНГОЛ УЛС
ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 03 сарын 07 өдөр

Дугаар А/152

Зуунмод

Газрын хэмжээг өөрчилж, газар эзэмших
эрхийг баталгаажуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6, 29.2, Газрын тухай хуулийн 37.1, 37.2 дахь заалт, Засгийн газрын 2018 оны 182 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2010 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 503 дугаар захирамжаар Зуунмод сумын Номт багийн нутаг Бараат уулын зүүн талд эзэмшиж буй 1500 м² газрын талбайн хэмжээг газрын кадастрын мэдээллийн санд байгаа гэрээ байгуулж, газрын төлбөр төлж ирсэн 15000 м² /1,5 га/-аар Пүрэвсүрэн овогтой Уламбаяр /НЮ83060779/-г үлдсэн 15 жилийн хугацаагаар шашны зориулалтаар эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмшигч иргэн П.Уламбаярт дараах үүргийг хариуцуулсугай.

2.1. Газрыг зориулалтын дагуу ашиглах

2.2. Газрын кадастрын зураглалыг мэдээллийн санд бүртгүүлж, газар эзэмших эрхийн гэрчилгээг авах.

2.3. Газар эзэмших гэрээ байгуулж, гэрээг жил бүр дүгнүүлэн газрын төлбөрийг хугацаанд нь бүрэн төлж байх.

2.4. Одоо объект баригдаж, хашаажсан 13500 м² газрыг суурь үнэ 1м²=2000 төгрөгөөр тооцож 27,000,000 /Хорин долоон сая/ төгрөгийг бүрэн төлөх.

3. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар /М.Отгонбат/, Зуунмод сумын Засаг дарга /Г.Мөнхбадрал/ нарт тус тус даалгасугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2010 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 503 дугаар захирамжийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ж.БАТЖАРГАЛ

01 00 397